

ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮД БОЛОН НАСАНД ХҮРСЭН ИРГЭДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

(ТҮРГЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН)





ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮД БОЛОН НАСАНД ХҮРСЭН ИРГЭДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

(Түргэн үнэлгээний тайлан)

Улаанбаатар хот
2025 он

**ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ӨСВӨР НАСНЫ
ХҮҮХДҮҮД БОЛОН НАСАНД ХҮРСЭН ИРГЭДИЙН
СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ**

(Түргэн үнэлгээний тайлан)

Үнэлгээний ажлын хэсэг

Д.Болормаа

Д.Тунгалаг

Сургагч багш

М.Цасчихэр

Б.Болорсайхан

Я.Мөнхчимэг

Д.Тунгалаг

Хянасан

Я.Мөнхчимэг

Цаасны хэмжээ: А5

Хэвлэлийн хуудас: 1.5 х.х

Дизайнер: Ж.Халиунцэцэг

ОРШИЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2024 оны 1 дүгээр сараас эхлэн эрх нь хязгаарлагдсан хүүхэд, залуус, иргэдийн сурч боловсрох эрхийн нөхцөл байдлын чиглэлээр нөлөөллийн ажил эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд хорих ангид олгож буй боловсролын өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах түргэн үнэлгээг хийлээ.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “Ази-Номхон далайн бүсийн суурь болон насанд хүрэгчдийн боловсролын нийгэмлэг” (ASP-BAE)-ийн “Насанд хүрэгчдийн боловсролын бодлогын нөлөөлөл” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 3000 долларын санхүүжилт авч, хоригдлуудын сурч боловсрох эрхийн чиглэлээрх нотолгоонд суурилсан бодлогын нөлөөллийн 6 сарын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл; Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйл; НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйл; Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай конвенц зэрэг хууль, конвенц, гэрээ, пактууд болон бодлогын баримт бичгүүдэд тодорхойлон заасны дагуу төрийн байгууллагууд хорих ангид байгаа иргэний төлөвших, нийгэмших, хөгжих, сурч боловсрох, соёлжин гэгээрэх асуудлаар үүрэг хүлээж, бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны гүйцэтгэх үндсэн чиг үүрэгт хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, холбогдох сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох чиглэлээр санал боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг тусгасан байна.

Харин шүүхээс оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх чиг үүрэг бүхий хорих анги нь хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох мөн хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох үйл ажиллагааг явуулах үүрэгтэй аж.



ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД, НАСАНД ХҮРСЭН ИРГЭД ГЭЖ ХЭН БЭ?

Хуульд заасан үндэслэл, журам, хугацаагаар хорих ангид тусгаарлаж, иргэний сонгуульд оролцох эрх гэх мэт зарим нэг эрхийг нь хассан иргэдийг “эрх нь хязгаарлагдсан хүүхэд, насанд хүрсэн иргэд” хэмээн нэрийдсэн нь БШУСайдын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/553 дугаар тушаалаар батлагдсан “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлд” дээрх нэрээр тодорхойлж, боловсролын үйлчилгээнээс орхигдоод байгаа бүлгийн нэг гэж үзсэн байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын (ШШГЕГ) харъяанд нийт 21 хорих анги (нээлттэй, хаалттай, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих хаалттай хорих анги гэсэн бүтэцтэй) үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрт хорих ялыг биечлэн эдэлж буй 4770¹ хүн, сургалт хүмүүжлийн тусгай төвд хүмүүжиж буй 54² өсвөр насныхан (14-21 насны) байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд³, “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй этгээдийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан Дүрэмд” эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй этгээд гэж тус тус орчуулсан байгаа бол, Хүүхэд хамгааллын тухай хуульд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд”⁴, Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “өсвөр насны хоригдол” хэмээн тус тус нэрлэн заажээ.

1 ШШГЕГ-аас ирүүлсэн албан бичиг “Хоригдлын боловсролын түвшинг тогтоох” судалгаа.УБ., 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар

2 Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл.УБ., 2024 он

3 (child deprived of liberty)

4

ЭРХ НЬ ХЯЗГААРЛАГДСАН ХҮҮХЭД, НАСАНД ХҮРЭГЧДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан сурч боловсрох эрх нь хүний үндсэн эрх. Эрх нь хязгаарлагдсан хүний сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй гэж НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага үздэг. Насан туршдаа суралцахуйн болон тэгш хамран сургах үзэл баримтлалын хүрээнд эрх нь хязгаарлагдсан иргэдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхээр Боловсролын хуулиудад заасан.

Сурч боловсрох эрх нь чадавхын эрх болохын хувьд хорих ангид байсан хүмүүст суллагдсаны дараа амьдралд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэх, гэр бүлийн амьдралаа хүний зэрэгт авч явахад голлох нөлөөтэй нь нотлогдсон⁵.

Хорих анги дахь боловсрол 3 гол ач холбогдолтой: (1) эрх нь хязгаарлагдсан иргэдийн дунд сурч боловсрох эрэлт хэрэгцээ өндөр байдаг, учир нь нийт хүн амтай харьцуулахад тэдний боловсролын түвшин доогуур байдаг. (2) боловсрол сургалтын үйл ажиллагаанд хамрагдсанаар хорих ангийн дэглэмтэй дасан зохицох, сэтгэцийн эрүүл мэнд сайн сайхан байдал дээшлэх, хорих анги дахь туршлага эерэгшихэд нөлөөтэй байдаг. (3) Суллагдсаны дараах үр өгөөж өндөр, тэдний ажил хөдөлмөр эрхлэх боломж тэлж, дахин гэмт хэрэгт холбогдох байдал эрс буурдаг.

НҮБ-аас 1990 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-ийн 5 дугаар зүйлд “Шоронд хоригдсон нөхцөл байдалтай холбоотойгоор шаардагдах хязгаарлалтуудыг эс тооцвол, бүх хоригдлууд нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан, мөн тухайн улс нь нэгдэн орсон бол Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт⁶, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁷ болон түүний нэмэлт протокол, бусад Нэгдсэн Үндэстний байгууллагын гэрээнүүдэд⁸ заасан эрхүүдийг бүрэн хадгалах ёстой” гэж, “Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд”-ын 6 дугаар зүйлд “Бүх хоригдлууд хүний зан чанарыг

5 НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгчийн тайлан, 2009 он, A/HRC/11/8

6 Пактын 2 ба 13 зүйл

7 Пактын 10.3 зүйл

8 Хүүхдийн эрхийн конвенцийн 2, 28 ба 29 зүйл, мөн Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенцийн 1 ба 4 зүйл

хөгжүүлэхэд чиглэсэн соёлын үйл ажиллагаа, боловсролын үйл ажиллагаанд оролцох эрхтэй” гэж тус тус заасан.

НҮБ-аас 1990 онд баталсан “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан журам”-д “Албан боловсрол эзэмших насны насанд хүрээгүй хүн бүр эрэлт хэрэгцээ, авъяас чадвартаа тохирсон нийгмийн амьдралд буцан ороход бэлтгэх зорилготой боловсрол эзэмших эрхтэй. Ийм боловсролыг боломжтой бол засан хүмүүжүүлэх газраас гадуур ердийн сургуулиар олгох” мөн, “Албан боловсрол эзэмших наснаас хэтэрсэн насанд хүрээгүй хүн үргэлжлүүлэн боловсрол эзэмшихийг хүсвэл түүнийг зөвшөөрч, дэмжлэг үзүүлбэл зохих бөгөөд тэднийг боловсролын зохих хөтөлбөрт хамруулахад шаардлагатай бүх зүйлийг хийвэл зохино” гэжээ. Мөн түүнчлэн мэргэжлийн багшаар заалгах, үндэсний хөтөлбөрөөр хичээллэх, хөгжлийн бэрхшээлтэй бол тусгай хэрэгцээт боловсрол эзэмших, хэл-соёлын хувьд нийлэмжтэй боловсрол эзэмших, бичиг үсгийн сургалтад хамрагдах эрхүүдийг баталгаажуулжээ.

2019 онд хорих анги дахь боловсролыг хүний эрхэд суурилсан өнцгөөс дүн шинжилгээ хийж үзээд “Хорих ангид боловсролыг зорилготой олгох нь хорих ангийн болон эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн амьдралыг өөрчлөх боломжийг нийгэмд олгодог. Хорих ангийн боловсролын эцсийн зорилго нь хорих ангийг хүмүүнлэг болгох гэдэгт эргэлзэх хэрэггүй”⁹ гэж судлаачид дүгнэсэн байдаг.

Хорих анги дахь боловсрол хүнийг бүх талаар хөгжүүлэх зорилготой байх ба албан ба албан бус боловсрол, бичиг үсгийн хөтөлбөр, суурь боловсрол, мэргэжлийн сургалт, шашны болон соёлын арга хэмжээ, бүтээл хийх, биеийн тамир спорт, иргэний боловсрол, номын сангийн үйлчилгээг багтаасан өргөн ойлголт¹⁰ мөн.

Энэхүү түргэн үнэлгээг гүйцэтгэхдээ дараах эх сурвалжуудыг ашиглав:

1. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн хүсэлтээр ЗГХЭГ-ын харьяа хэрэгжилт хариуцсан агентлаг Боловсролын Ерөнхий Газар, БЗД-ийн Насан туршийн боловсролын төвийн хийсэн хоригдлуудын боловсролын эрэлт хэрэгцээний талаарх судалгаа, үнэлгээ, тайлан. Тухайлбал,


9 International Review of Education, produced at UIL, published a special issue entitled ‘Education in Prison: A Basic Right and an Essential Tool’ Guest editors Hugo Rangel Torrijo and Marc De Maeyer (2019, p. 677)

10 НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгчийн тайлан, 2009 он, A/HRC/11/8

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа (2024 оны 1 дүгээр сар)
 - Баянзүрх дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан 3 хорих ангид хүмүүжигчдээс авсан Боловсролын эрэлт хэрэгцээний дэлгэрэнгүй судалгаа (2024 оны 2 дугаар сар)
 - Хорих ангид боловсрол, сургалтын үйл ажиллагаа (бичиг үсгийн, боловсрол нөхөн олгох, мэргэжил эзэмших, боловсролын зэрэг олгох, бие хүний төлөвшилд эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа) зохион байгуулах бэлэн байдлын үнэлгээ (2024 оны 6 дугаар сар)
 - Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад явагдаж байгаа сургалт, хүмүүжлийн ажлын нөхцөл байдлын тайлан (2024 оны 7 дугаар сар)
 - Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургуулийн зарим үйл ажиллагаанд боловсролын хяналтын чиглэлээр хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнгийн тайлан (2024 оны 5 дугаар сар)
2. “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн төрийн бус байгууллага, хүний эрх, жендэрийн чиглэлээр мэргэшсэн, үндэсний сургагч багш нар чиглүүлэн зохион байгуулсан сургалтын мэдээлэл, тухайлбал:
- 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги;
 - 409 дүгээр хаалттай, нээлттэй хорих анги;
 - 421 дугаар нээлттэй хорих анги;
 - 429 дүгээр хаалттай хорих анги-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,
 - Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэрэгдэх Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургууль;
 - 425 дугаар нээлттэй хорих анги (Говьсүмбэр аймаг)
 - 405 дугаар хаалттай (тусгай нэгж) хорих ангиудад танхимын буюу бүлгийн сургалт, ганцаарчилсан сургалт, үйл ажиллагаа
3. Холбогдох баримт бичгүүдийн судалгаа

Хорих байгууллагад явуулж буй бүх төрлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа болон хоригдолд боловсрол олгож буй байдалд хийсэн дүн шинжилгээ

2024 оны байдлаар нийт 4477 хоригдол хорих ял эдэлж байгаагийн 2204 нь буюу 49,2% нь 16-35 насны залуус байна.



Эх сурвалж. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа, 2024 он


Тэдний 574 нь боловсролгүй, 1561 нь заавал эзэмших боловсролыг дүүргээгүй байна. 602 хоригдол бага боловсрол эзэмшилгүй сургуулиас завсардсан байна.



Эх сурвалж. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа, 2024 он

Коллеж, мэргэжлийн болон техникийн сургуульд хамрагдаж байгаад хоригдсон 16 хүн, их дээд сургуульд сурч байгаад хорих ангид ирсэн 40 хоригдол байна.

Судалгаанд хамрагдсан 4477¹¹ хоригдлоос ямарваа нэг мэргэжилгүй 2250 хоригдол байсан.



Эх сурвалж. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа, 2024 он

Судалгаанд хамрагдсан нийт 4477 хоригдлын 3004 хоригдол буюу 67% нь цаашид ял эдлэх хугацаандаа сурах хүсэлтэй гэдгээ илэрхийлжээ.

11 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа (2024 оны 1 дүгээр сар)



Эх сурвалж. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хийсэн хорих ял эдэлж буй хоригдлуудын боловсролын судалгаа, 2024 он

1565 хоригдол ямар нэг мэргэжил эзэмших сургалтад, 177 нь бичиг үсгийн сургалтад, 346 нь ерөнхий боловсрол эзэмшүүлэх, 247 нь зан үйлд нөлөөлөх, 380 нь амьдрах ухааны ур чадвар олгох, 50 нь хууль эрх зүйн сургалтад хамрагдах, 12 нь их дээд сургуульд суралцах хүсэлтэй гэжээ.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрхээ хязгаарлуулсан насанд хүрэгчдэд боловсрол олгож буй байдал

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөнд “ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх” талаар маш тодорхой тусгасан.

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн А/167, А/233-р хамтарсан тушаалаар “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр” болон ШШГЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр баталсан хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг хөдөлмөр, сургалттай хослуулан, мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, амьдралын зөв дадал, харилцааны эерэг зан үйлийг төлөвшүүлэх зорилго бүхий “Хорих ял эдлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр” баталсан ба тус хөтөлбөрүүдийн зорилго нь хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гарахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаа, хөдөлмөрийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудын зүгээс үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний салбар дундын зохицуулалтыг хангахад оршиж байгаа болно. Энэхүү хөтөлбөрийн хамрах хүрээнд төрийн байгууллаас гадна аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулахаар зохицуулсан.

ШШГЕГ-аас ирүүлсэн мэдээллээс¹² харахад 2024 онд хоригдлуудын дунд бясалгалын, харилцааны ур чадварын, мансууруулах бодис, хар тамхи, согтууруулах ундаа хэрэглэх хорт зуршлаас татгалзах, хор нөлөөг ойлгуулах, гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан ба хоригдлын авъяас, ур чадварыг хөгжүүлэх, сонирхолд нь тулгуурлан төрөл бүрийн дугуйлан, хөдөлмөрлөх дадлага олгох сургалт (монгол бичиг, англи хэл, хөгжим, бүжиг, спорт, нэхмэл сүлжмэлийн зэрэг) зохион байгуулжээ. Мөн Насан туршийн боловсролын төвтэй хамтран оёдол, эсгүүр, компьютер, үсчний сургалтыг зохион байгуулж, хоригдлуудын дунд янз бүрийн сэдвээр аян зохион байгуулсан нь үр дүнтэй болжээ. Зарим хорих анги, ШШГГ

12 ШШГЕГ-ын 2025 оны 1 сарын 26-ны өдрийн 02/41 тоот албан хариу

нь хоригдлыг “Суллахад бэлтгэх байрыг” шинээр байгуулах, засварлах, тохижуулах ажлыг хийж эхэлсэн нь сайшаалтай.

Прокурорын байгууллагаас хоригдлын сургалт, нийгэмшүүлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж буй байдалтай сүүлийн 5 жилийн хугацаанд 328 удаа танилцаж, 141 шалгалт хийсэн бөгөөд энэ явцдаа 245 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар ажилласан байна¹³.

Прокурорын хяналт, авсан арга хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Нийт
Шалгалт	17	18	47	27	32	141
Судалгаа	-	-	1	3	-	4
Танилцах ажиллагаа	59	53	73	64	79	328
Үүнээс гэнэтийн танилцах ажиллагаа	19	16	27	21	31	114
Илрүүлсэн зөрчил	10	25	69	70	71	245
Прокурорын шаардлага	2	6	10	4	11	33
Харилцлага тооцуулсан	-	2	1	-	1	4

Эх сурвалж. Монгол улсын Ерөнхий прокурорын газрын 2025 оны 1 сарын 10-ны 1/274 тоот албан бичиг

Прокурорын хяналт, шалгалтаар хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс хоригдлыг сургах, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахдаа тэдний үйлдсэн гэмт хэргийн болон хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцаарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж, үе шаттай, ялгамжтай зохион байгуулдаггүй, мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутмаг, нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хангах, тооцох байдал зарим хорих ангиудад хангалтгүй зэрэг зөрчил дутагдал илэрчээ.¹⁴

Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөрийн талаар хорихоос суллагдсан 325 хүний дунд явуулсан судалгаагаар 111 хүн буюу 34.2 хувь нь энэхүү хөтөлбөрийн талаар мэдэхгүй гэж хариулсан бол 71 хүн буюу 21.8 хувь нь хөтөлбөрийг үр дүн муутай ач холбогдолгүй буюу амьдралд хэрэгждэггүй, 143 хүн буюу 44 хувь нь тус хөтөлбөрийн сургалтад хамрагдсан бөгөөд

13 Монгол улсын Ерөнхий прокурорын газрын 2025 оны 1 сарын 10-ны 1/274 тоот албан бичиг

14 МУ дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, ХЭҮК, 2024 он

суллагдсаны дараа амьдралд хэрэгцээтэй байсан гэж хариулжээ. Суллагдахад бэлтгэх хөтөлбөрийн үр дүнгийн талаар хорих ангийн тухайн асуудал хариуцсан 58 алба хаагчаас судалгаа авахад 9 нь буюу 15.5 хувь нь үр дүнгүй, 44 нь буюу 75.9 хувь нь суллагдсаны дараа үргэлжлүүлэн нийгэмшүүлэх орчин дутагдалтай, 5 нь буюу 8.6 хувь нь үр дүн сайтай гэж хариулжээ.

Монгол Улсын хувьд хорих байгууллагад нийгэмшүүлэх хөтөлбөр, хорихоос суллагдахад бэлтгэх хөтөлбөр, суллагдсаны дараа хяналт тавих, дэмжлэг үзүүлэх зэрэг нийгэм, эдийн эдийн шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч санхүүгийн нөөц бололцоо дутмаг, хяналт тавих хүний нөөц, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, үүрэг хүлээгч байгууллагуудын хамтын ажиллагаа сул, олон нийтийн сөрөг хандлагаас шалтгаалан хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, бодитой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж ХЭҮК үзжээ.

Бидний мэдээлэл цуглуулсан хорих ангиудад сургалтын анги танхимгүй, байгаа нь хүрэлцээгүй, гэрэлтүүлэг, агааржуулалт муутай, интернетийн хурд муу тул цахимаар хичээллэх боломжгүй, зарим хорих анги номын сангүй, сурах бичиг, сургалтын материал байхгүй, хоригдлуудад сургалтын хэрэглэгдхүүн байхгүй, сургалт явуулахад шаардагдах самбар, дэлгэц, проектор зэрэг техник хэрэгсэл дутмаг¹⁵ зэрэг нөхцөл байдалтай байв.

“Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн салбар дундын зохицуулалтыг ШШГЕГ, ХГБХХЕГ, ХХҮЕГ, ХНХСҮСИ, ЦЕГ, УБЕГ хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, үр нөлөөг хангахын тулд дээрх байгууллагуудыг уялдуулан хэрэгжүүлэх зохицуулалтыг хангах талаар хариуцсан яамны чиг үүргийг хорихоос суллахад бэлтгэх хөтөлбөрт тусгах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-аас 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийг баталж, уг хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсэгт “Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-аас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад суралцах хүсэлт гаргасан бол хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга

15 БЗД-ийн насан туршийн боловсролын хэлтсийн тайлан мэдээлэл, 2024 оны 6 дугаар сар

шийдвэрлэнэ” гэж заасан. Уг зохицуулалттай холбоотойгоор хаалттай хорих ангид хорих ял эдэлж буй бүхий л хоригдол, нээлттэй хорих ангид ял эдэлж буй зарим (хорих ялынхаа 50-аас доошгүй хувийг эдлээгүй) хоригдлууд аливаа сахилгын зөрчил гаргаж байгаагүй, сургалт хүмүүжлийн аливаа хөтөлбөрт хангалттай хамрагдсанаас үл хамааран их, дээд сургууль, коллежийн сургалтад хамрагдах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 236.1 дэх заалтаас шалтгаалан эрхээ хязгаарлуулсан иргэдийн сурч боловсрох эрх зөрчигдсөн кейс

Кейс 1:

Боловсролын яам, Боловсролын Ерөнхий газраас Боловсролын ерөнхий хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ШШГЕГ-ын 407, 409, 421 дүгээр хорих ангиудаас их сургуульд үргэлжлүүлэн болон шинээр бакалавр, магистр, докторын сургалтанд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийн сурч боловсрох эрхийг хангахаар ажиллаж эхэлсэн. БШУЯ-ны Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газраас ШУТИС-ын Эрдэм шинжилгээ, технологи эрхэлсэн проректор Д.Цолмонбаатарт хоригдол С.Б (421 дүгээр ангид ял эдэлж байгаа бөгөөд танхимын сургалтаа дүүргэсэн) -ийн “Тээврийн менежмент, зохион байгуулалт” мэргэжлээр судалгааны ажлаа үргэлжлүүлэн бичиж, докторын зэргээ хамгаалах хүсэлтийг дэмжин ажиллах тухай албан бичгийг явуулсан ба 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр тус сургууль нь дэмжин ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. Гэвч иргэн С.Б нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 236.1 заалт дахь “...хорих ялын 50-иас дээш хувийг эдэлсэн...” гэсэн шалгуурыг хангаагүй гэсэн шалтгаанаар ШУТИС-д үргэлжлүүлэн сурах боломжгүй болсон.

Кейс 2:

407 дугаар хорих ангийн “хаалттай” дэглэмд хорих ял эдэлж байгаа З.С нь СУИС-ийн зураачийн ангид суралцах өргөдлөө бичиж өгсөн боловч мөн л дээрх заалтын “...Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн...” гэсэн хязгаарлалтын дагуу их сургуульд суралцах боломжгүй болсон.

Кейс 3:

БШУЯ-ны Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газраас 2024 оны 9 дугаар сарын 9-ний өдөр ШУТИС-ийн Сургалт, цахим шилжилт хариуцсан проректор Н.Эрдэнэхүүд оюутан Ч.Б-ын /407 дугаар хорих ангид ял эдэлж байгаа/ оюутны кредит дүйцүүлэлтийг бодуулан гаргуулж авах мөн суралцах үйл ажиллагааг нь дэмжин, хамтарч ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн ба тус сургууль нь оюутны кредит дүйцүүлэлтийн хуудсыг илгээж, хүнсний чанар аюулгүй байдал хөтөлбөрт оюутан Ч.Б-ыг үргэлжлүүлэн сургаж, дэд бакалаврын зэрэгтэйгээр төгсгөх тал дээр дэмжин, хамтран ажиллах саналаа албан бичгээр ирүүлсэн. Гэвч ШШГЕГ-ын Сургалт, нийгэм сэтгэл зүйн албанаас Ч.Б-сг 236 дугаар зүйлийн 1 дэх заалтын "...сахилгын зөрчил гаргаж байгаагүй..." гэх шалтгаанаар ШУТИС-д үргэлжлүүлэн сурах боломжгүй гэсэн хариу өгсөн.

Кейс 4:

407 дугаар хорих ангийн нээлттэй дэглэмд хорих ял эдэлж байгаа Л.М нь МУБИС-ийн англи хэлний багшийн ангид суралцах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн өргөдлөө өгч, 2024 оны өвлийн ЭЕШ-нд орсон боловч мөн л дээрх заалтын "...Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн..." гэсэн хязгаарлалтын дагуу их сургуульд суралцах боломжгүй гэсэн шийдвэр гаргасан байна.

- **ШШГЕГ-ын харьяа "Амгалан" Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага**

ШШГЕГ-ын харьяа "Амгалан" Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь 2012 онд байгуулагдсан бөгөөд хүмүүжигчдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтаар дамжуулан ур чадвар олгож, ажлын байраар хангах, гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх, эзэмшсэн мэргэжил, ур чадвараараа хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц ажилтан бэлтгэх зорилготой байгуулагдсан.

"Амгалан" Мэргэжлийн боловсролын сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд нийт 21 багш ажилчидтай, үүнээс үндсэн 12 багштай үйл ажиллагаагаа явуулж байна.

2023-2024 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн сургалтыг 8 мэргэжлээр (тогооч, гагнуурчин, бетон арматурчин, барилгын өрлөг угсрагч, цахилгаанчин, сантехникч, мужаан, засал чимэглэлчин) 202 хүн суралцуулж төгсгөсөн ба 15 мэргэжлээр чадамж эзэмшүүлэх 30 хоногийн сургалтад нийт 512 суралцагч суралцаж төгссөн.

Тус сургалтын байгууллага нь одоо ШШГЕГ-ын 409 дүгээр хорих ангийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа хуучин өөрсдийн байртай байхдаа хорих ангиудаас сурах хүсэлтэй хүмүүсээ авчирч сургадаг нь үр дүнтэй байсан учир энэ тогтолцоогоо сэргээх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. ШШГЕГ-ын төлөвлөгөөт сургалтаас бусад сургалтыг орон нутгийн МБС-аар дамжуулан зохион байгуулах боломжийг судлах шаардлагатай гэв.

“Амгалан” МБСБ нь ШШГЕГ-ын харьяанд байдаг гэдэг нь Монгол улсад нээлттэй мэдээлэлтэй байдаг. Энэ байгууллагыг “ШШГЕГ-ын харьяа” гэх тодотголтой байлгах нь нэгэнт хорих ял эдлээд дууссан иргэдийн хөдөлмөрлөх эрх болон бусад олон эрхүүдэд халдаж байгаа ноцтой асуудал юм.

Хорих ангид байх хугацаанд “Амгалан” МБСБ-д суралцуулан, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгож байгаа нь сайшаалтай боловч, хорих ял эдэлж дуусаад нийгмийн харилцаанд орж, ажил хөдөлмөр эрхлэхээр аль нэг компанид ажилд орох болоход тухайн компанийн хүний нөөцийн мэргэжилтнүүд, удирдлагууд, бусад ажилтнууд “Амгалан” МБСБ олгосон мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээг хараад л суллагдсан иргэний хорих ангид ял эдэлж байсан тухай хувийн мэдээлэл нь бусдад ил болдог учир ажилд авахаас шууд татгалздаг байна.

Амгалан МСҮТ нь мэргэжлийн ном сурах бичиг хангалттай, үйлдвэр сургалтын дадлага хийдэг, хорих анги бүр дээр цехүүд байдаг учир төгсөгчид нь ажлын байртай зэрэг давуу талуудтай.

Гэвч “Амгалан” Мэргэжлийн боловсролын сургуулийн хувьд нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар санхүүждэггүй, хорих ангийн суралцагчдад тэтгэлэг олгодоггүй, сургалтын багаж тоног төхөөрөмж нэг хүнд ноогдох нормоороо хүрэлцдэггүй, явуулын сургалт хийдэг учир багшид зөөврийн компьютер дутмаг, проектор, ухаалаг самбар байхгүй, тогооч мэргэжлийн ном сурах бичиг хангалтгүй, багш нар хөдөө орон нутагт сургалт зохион байгуулахад ар гэрт хүндрэлтэй байдаг зэрэг асуудлууд тулгамдаад байна. Мөн мэргэжлийн сургалтанд хамрагдаж байсан хүмүүс хугацаанаасаа өмнө суллагдах тохиолдолд тэдгээр хүмүүст мэргэжлийн үнэмлэх олгогдоггүй учир суллагдаж байгаа хүмүүс хохирсоор байгаа гэв.

Эрхээ хязгаарлуулсан өсвөр насны хүмүүжигч нарт боловсрол олгож буй нөхцөл байдал

Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх, өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулахад хорих анги туслалцаа үзүүлэхээр¹⁶ хуульчилсан байдаг.

ШШГТХуульд “Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна” гэж заасны дагуу Нийслэлийн ЕБС-ийн 110-р сургууль ШШГЕГ-ын 411 дүгээр сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын байранд боловсрол сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

- **ШШГЕГ-ын харьяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэдэх Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургууль**

2000 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 258 тоот захирамж гарч, Зайсан дахь Насанд хүрээгүйчүүдийн хорих ангид “Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай сургууль” байгуулагдсан.

Нийслэлийн боловсролын газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн тушаалаар Монгол улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Хан-уул дүүргийн 110 дугаар дунд сургууль болсон бөгөөд Нийслэлийн боловсролын газраас 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр тус сургуулийн ангиллыг өөрчилж, бүрэн дунд сургууль болгож, сургалт явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгожээ.

Одоо тус сургууль нь 2016 оноос Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажилагааг явуулж байгаа ердийн хэв шинжтэй, төрийн өмчийн сургууль байна. 2024 оны байдлаар тус сургуульд нийт 47 хүүхэд сурч байснаас 45 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй байв.

Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хоригдол хүүхдүүдийг нийгэмшүүлэх, сэтгэл зүй, зан чанар, засрал хүмүүжил, төлөвшилд нь эерэг нөлөөлөл үзүүлэх, ерөнхий боловсрол олгох, хичээлийн хоцрогдол арилгах, мэргэжлийн баримжаа олгох, хөдөлмөрийн дадал олгох сургалтанд тус тус хамруулж байна¹⁷.

16 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.2017 он

17 ШШГЕГ-ын 2025 оны 1 сарын 26-ны өдрийн 02/41 тоот албан хариу

Тус сургуулийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавьсан прокурорын хяналтын тоон судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл:

Прокурорын хяналт, авсан арга хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Нийт
Шалгалт	5	5	5	7	5	27
Судалгаа	-	-	-	7	-	7
Танилцах ажиллагаа	13	14	16	15	13	71
Үүнээс гэнэтийн танилцах ажиллагаа	3	4	3	2	2	14
Илрүүлсэн зөрчил	10	-	26	23	37	96
Прокурорын шаардлага	3	-	1	2	3	9

Эх сурвалж. Монгол улсын Ерөнхий прокурорын газрын 2025 оны 1 сарын 10-ны 1/274 тоот албан бичиг

Нийслэлийн прокурорын газраас 2022 онд тус байгууллагад “Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээгээр тогтоосон стандарт, нөхцөл, дэглэмийн хэрэгжилт”-ийг шалгахад өсвөр насны хоригдолд олгож байгаа боловсролын үйл ажиллагаа болон ял эдлэх нөхцөл, дэглэм нь хууль тогтоомжинд нийцээгүй, өсвөр насны хоригдлын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрх нь зарим талаар зөрчигдсөн¹⁸ гэсэн дүгнэлт гарсан байна.

Шалгалтаар сургуулийн барилга зориулалтын бус, сургалтын орчин бүрдээгүй, номын сан, уншлагын танхим шаардлагад нийцээгүй, хуурамч дипломтой 1 багш болон мэргэжлийн бус багш нар ажиллуулсан, суурь болон бүрэн дунд боловсролын сургалтыг холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, стандартын дагуу явуулаагүй, сургуулийн дүрэм, журамд хүүхдийн эрх хамгааллын талаар заалт тусгаагүй, дотоод журамгүй зэрэг зөрчлүүд илэрчээ. Шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч, зарим зөрчлийг арилгасан ч зарим асуудлууд өнөөдөр хүртэл шийдвэрлэгдээгүй байгааг прокурорын байгууллага мэдээлсэн байна.

18 Монгол улсын Ерөнхий прокурорын газрын 2025 оны 1 сарын 10-ны 1/274 тоот албан бичиг

Тус сургуульд 2024 оны 5 дугаар сарын 13-наас 14-ний өдрүүдэд 2 дахь шалгалтыг Нийслэлийн боловсролын газрын боловсролын хяналтын улсын ахлах байцаагч А.Танан-Эрдэнэ хийсэн. Шалгалтаар хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын холбогдох заалтуудыг хангаагүй нь тогтоогдсон бөгөөд 6-12 дугаар ангиудад заавал судлах хичээл бүрэн ордоггүй, ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж мөрдөөгүй, багш нарын ээлжит хичээлд хяналт тавдаггүй, сургалтын ажлын баримт бичгийн хөтлөлтөд хяналт тавьж, үнэлгээ хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн ба илэрсэн зөрчлүүдийг арилгуулах, шалгалтын мөрөөр зохих ажлыг эрчимжүүлэх чиглэлээр талаар 9 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн байна¹⁹.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын захирагч Ц.Хишигбаяр сургуулийн захирлын албыг хавсран гүйцэтгэдэг. Одоогоор 6 багшийн орон тоотой үүнээс тэтгэврийн насны 3 багш, сургалтын менежер, нягтлан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч номын санчтай.

Хичээлийн үйл ажиллагаанаас гадна хүмүүжигчид ОУБ болон ТББ-ын дэмжлэгтэйгээр талх нарийн боов, дүрслэх урлаг, хөгжим, ноосон урлал, хоол бэлтгэл, гагнуур, барилгын дотор засал, таеквондогийн зэрэг сургалтад хамрагдаж байна.²⁰

СХТБ-д хүмүүжиж байгаа хүүхдүүдээс сургуульд сурахтай холбоотой хүндрэл бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон байна²¹.

19 Нийслэлийн боловсролын газрын 2024 оны 8 сарын 29-ний 6/1541 тоот албан бичиг, хавсралтаар 2024 оны 5 сарын 14-ний өдрийн хяналт шалгалтын танилцуулга

20 БЕГ-ын ТХСХ-ЭЭС Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаатай танилцсан тэмдэглэл, 2024 оны 07 сарын 03-ны өдөр

21 Кристина Ноблийн Хүүхдийн Сангийн захиалгаар гүйцэтгэсэн “Өсвөр насныхны хөгжлийн хөтөлбөрийн суурь судалгаа”, “Эс Ай Си Эй” ХХК, 2024

Хүмүүжигч хүүхдүүд сургуульд сурахтай холбоотой тулгардаг хүндрэл бэрхшээл

Бэрхшээлтэй асуудлууд	Тайлбар жишээ
А. Сургуулийн орчин, нөөцтэй холбоотой	- Хичээлийн байр орчин нөхцөл тааруу, тав тухгүй - Бүх ангийн хичээл нэг л танхимд хичээллэдэг - Хичээлийн танхим зай талбай бага - Хичээл, гэрийн даалгавар хийх орчин нөхцөл муу; - Хичээлийн хэрэгсэл дутагдалтай; - Сургууль хорих байгууллагын дотор байрладаг; - Бие засах газар гаднаа, ариун цэвэр сахих боломжгүй;
Б. СХТБ-ын журам дүрэм, дэглэм, үйл ажиллагаатай холбоотой	- Хүний эрхэнд байдаг; - Хооллох, босох, унтах, чөлөөт цаг бүгд хязгаартай; - Өглөө бүр 7 цагаас босох; - Шагналын хоног авах гэж олон төрлийн сургалтад суух;
В. Сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалттай холбоотой	- Багшийн дутагдал /жнь: физик, технологи гэх мэт - Зарим хичээл цаг бага /жнь: төгсөх ангийн хичээл/ - Хичээл, даалгавар хийх цаг хүрэлцдэггүй; - Хичээл дээр орж, гарч, шуугих нь их, анхаарал төвлөрдөггүй; - Ганц нэг багш хэт их үглэж шүүмжилдэг;
Г. Хувь хүний хөгжил, төлөвшилтэй холбоотой	- Уншиж, бичиж чаддаггүй; - Биологи/бэлгийн амьдрал заах болохоор ичдэг;
Д. Хүмүүс хоорондын харилцаатай холбоотой	- Албадлага, хэт захиргаадсан, зааварчилсан; - ЭЕШ өгөхөд хүүхдүүд муухай хараад байдаг; - Хүүхдүүд нэг нэгнээ элдэв үгээр хэлэх;
Е. Гэр бүлтэй холбоотой	- Гэрээсээ хол байдаг, гэрийнхнээ их санадаг; - Хүссэн үедээ уулзаж, ярьж чаддаггүй; - Эргэлт ирдэггүй;

АСУУДАЛ. Хүүхдүүдийн байрлаж буй байрны нөхцөл хүнд байна

Сургуулийн барилга нь 1960 онд баригдсан, 76 жил болсон барилга бөгөөд Мэргэжлийн хяналтын 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 07-208/638 дугаар улсын байцаагчийн дүгнэлтээр барилга байгууламжууд нь ашиглалтын шаардлага хангахгүй, хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна гэсэн дүгнэлт гарсан бөгөөд Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2020 оны 8 сарын 28-ны өдрийн 02-07-383/64 дугаартай актаар нураах шийдвэр гарсан.

Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургуульд 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Боловсролын ерөнхий газрын мэргэжилтнүүдтэй очиж ажиллахад өсвөр насны хоригдлуудын амьдрах байр, сургууль нэг дор бөгөөд олон улсын стандарт, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоодын хууль тогтоомжийн дагуу нэг хоригдолд 2.5 кв талбай ноогдохоор заасан ч энэ нөхцөл СХТБ-д хангагдаагүй, нэг өрөөнд хэт олон хүүхэд амьдарч буй нөхцөл байдалтай, орчин нөхцөл нь хэт хүйтэн, чийгтэй, тав тухгүй байлаа.

2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулганаар Монгол Улсын “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц”-ын хэрэгжилтийн тайлан-илтгэлийг хэлэлцээд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хууль зөрчсөн хүүхдүүдийн байрны материаллаг нөхцөл хангалтгүй байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлээд өсвөр насны хоригдлуудын амьдрах нөхцөлийг яаралтай сайжруулах²² зөвлөмжийг өгчээ.

2024 оны 9 сараас шинэ цогцолбор барилгын ажил эхэлсэн ба 2026 онд баригдахаар төсөв батлагдан, хэрэгжүүлэх шатанд явж байна.

АСУУДАЛ. Сургалтын орчин нөхцөл хангалтгүй

Нийт сургалтын зориулалттай 4 танхимтай, анги танхимын орчин нөхцөл, тохижилт тааруу, зай талбай муутай, гэрэлтүүлэг муу, ширээ сандлын хүрэлцээ муу, 1-12 дугаар ангийн сурах бичгүүдийн нөөц байхгүй, номын сангийн үйлчилгээний хүртээмж муу, номын фонд хуучирсан байдаг ба тогтмол шинэчилдэггүй, сурах бичиг байдаггүй.

Шаардлага хангасан самбар болон хичээл сургалтад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн (компьютер, принтер, хор, поректор, зурагт-дэлгэц, уртасгагч, бичгийн цаас, дэвтэр, бал, харандаа, баллуур.....) нь хүрэлцээ муутай, ашиглах хугацаа хэтэрсэн, хуучирч элэгдсэн, нөөц байхгүй.

Хичээл, гэрийн даалгавар хийх орчин тав тухгүй, хүйтэн, номын сан, сургалтын өрөөнд интернэт орчин бүрдээгүй. Элсэлтийн шалгалтад бэлтгэж буй болон бүх шатны боловсролд хамрагдаж буй хүмүүсийг хичээл, шалгалтдаа бие даан бэлтгэх боломж нөхцөлийг бүрдүүлэх тал дээр анхаардаггүй.

22 НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Монгол улсын ээлжит 3 дах тайлангийн ажиглалт, дүгнэлт, 2024 оны 12 сарын 11, (Албан бус орчуулга)

АСУУДАЛ. Суралцагчийн сайн сайхан байдал хангагдах нөхцөл бүрдээгүй

Хүүхдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг хүүхэд бүрээр хийсэн оношилгооны үр дүн, нотолгоо баримтад суурилан боловсруулж хэрэгжүүлдэггүй, эдгээр нийгэмшүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтнүүдийн дунд хэрэглэгдэх жишиг хөтөлбөр, арга, аргачлал байхгүй,

Хүмүүжигчдийн боловсрол, зан үйл, нийгэмшлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, хүүхдийн нийгэмшилд гарсан ахиц өөрчлөлтийг хэмжих, цаашилбал, бүхий л төрлийн хөтөлбөрийн үр дүнг тооцох боломж одоогоор маш бага байна.

Хүүхдийн сэтгэл зүйн нөхцөл байдал, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлт хүчин зүйл зэргийг үнэлэх стандарт аргачлал байхгүй, тэднийг гэр бүлтэй нь холбон зуучлах, суллахад бэлдэх, нийгэмд тогтвортойгоор эргэн нэгдэхэд дэмжлэг үзүүлэх байдал туйлын хангалтгүй байна.

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь мэргэжлийн бус, эрх зүйч мэргэжилтэй төрийн тусгай албан хаагч нар байдаг ба Хүүхэд хамгааллын баггүй, төлөвлөгөө огт гаргадаггүй мөн хорих ангийн болон сургуулийн төсөвт хүүхэд хамгааллын зардлыг суулгаж байгаагүй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейс гарсан ч хэрхэн шийдвэрлэгдэж байгаа нь тодорхойгүй.

АСУУДАЛ. Хорих ял эдэлж дуусаад харьяаллын дагуу сургуулиудад шилжин суралцах үед тулгардаг ялгаварлан гадуурхалт

Хүүхдүүд хорих ял эдлэж байх хугацаандаа 110-р сургуульд суралцдаг бөгөөд хорих ял эдэлж дуусаад харьяаллын дагуу сургуулиудад шилжин суралцах үед тухайн хүүхдийн сурагчийн хувийн хэрэгт “110-р сургуульд суралцаж байсан” тухай нь тэмдэглэгддэг ба 110-р сургуулийг ШШГЕГ-ын харьяа гэдгийг иргэд, багш нар төдийгүй зарим хүүхдүүд мэддэг нь амьдралдаа алдаа гаргасан хүүхдүүдийг сургуульд үргэлжлүүлэн сурахаас ичих, ялгаварлан адуурхалд өртөх, сургуульд суралцахаас зайлсхийхэд хүргэх тохиолдлууд гарсаар байна. 110-р сургуулийг “ШШГГ-ын харьяа сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэдэх” гэсэн тодотголтой байлгах нь хүүхдийн сурч боловсрох болон бусад олон эрхүүдийг зөрчихөд хүргэдэг ноцтой асуудал юм. “Засан хүмүүжүүлэх байгууллагад байгаа

насанд хүрээгүй хүнд олгосон боловсролын диплом, гэрчилгээнд тухайн хүнийг засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байсныг нь мэдэгдэх ямар нэгэн тэмдэглэл хийж болохгүй,²³” гэж НҮБ-аас хүүхдийн эрхийг хамгаалсан байдаг.

Нийгмийн халамжийн тухай хуульд “хорих ангиас суллагдсан хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлнэ” гэж заасан байдаг ч хэрэгжилт маш муу байдаг.

АСУУДАЛ. Хуулийн хэрэгжилтийн алдаа

2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага гэсэн шинэ нэр томьёонд хэрхэн ял эдлүүлэх талаар нэгдсэн ойлголт үгүй байна. Учир нь хуучин насанд хүрээгүйчүүдийн хорих анги, өнөөгийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь нэр томьёоны болон үйл ажиллагааны онцлогтой болох нь дамжиггүй юм.

Олон Улсын жишгээс харахад Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь ял эдлүүлэх чиг үүргээсээ илүү сургалтын болон нийгэмшүүлэх үйл явцыг хэрэгжүүлдэг сургалтын орчин нөхцөлтэй байгууллага байна. Гэвч манай улсад Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын орчин нөхцөл нь хорих ангийн орчин нөхцөлтэй ижил, зарим талаараа тааруу байгаа нь учир дутагдалтай байна.

Практикт “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-ын үйл ажиллагааг нэг мөр ойлгоогүй, тусдаа эрх зүйн зохицуулалт байхгүйгээс насанд хүрэгчдийн нэгэн адил хорих нөхцөл, журам мөрдөж байгаагаас зарим нэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Эрх бүхий захиргааны байгууллагаас журам, зааврыг гаргахдаа насанд хүрээгүй этгээдийн эрх, эрэлт хэрэгцээ, шаардлага, үндсэн онцлогийг бүрэн харгалзсан хэм хэмжээг тогтоохыг НҮБ-аас гаргасан дүрэмд²⁴ тусгасан байдаг.

23 Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан журам, НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 68 дугаар хуралдаан, 1990 оны 12 сарын 14

24 Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүй этгээдийг хамгаалахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан дүрэм, Ерөнхий Ассемблейн 68 дугаар хуралдаан, 1990 оны 12 сарын 14

Иймээс Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын сургалтын болон нийгэмшүүлэх, нөхцөл, журамтай холбоотой журмыг батлан үйл ажиллагаандаа дагаж мөрдөх нь зүйтэй гэж зарим судлаачид үзсэн байна.

“Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллагын гол зорилго нь халамж, хамгаалалтаар хангах, нийгэмд ашигтай, нийгэмд үр бүтээлтэй үүрэг биелүүлэхэд нь боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэнэ. (26.1 дэх хэсэг)²⁵ гэж олон улсад үздэг. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь сургалтын байгууллага байхаар зохицуулсан дотоод журмыг боловсруулан Боловсролын асуудал эрхэлсэн болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар батлуулах, тус байгуулллагын нийт алба хаагчдыг хүүхэдтэй ажиллах арга барил эзэмшсэн багш мэргэжилтэй хүмүүсийг түлхүү авч алба хаагчдыг мэргэшүүлж ажиллуулахыг судлаачид зөвлөж байна.

АСУУДАЛ. Салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа дутмаг

Боловсролын ерөнхий хуулийн 10.1.11-д суралцагч нь. “ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах” эрхтэй гэж заасан ч нэг талаас ЕБС, нөгөө талаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тусгай чиг үүргийн байгууллага тул хоёр салбарын дунд шийдэгдэхгүй орхигдох, суралцагчдын хууль ёсны эрх, эрх ашиг зөрчигдөх асуудал цөөнгүй байна.

Боловсролын салбараас үзүүлдэг тусгайлсан дэмжлэг байхгүй, сурах бичгийн хуваарилалт хийгддэггүй гэх мэт хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, хүний эрх, боловсролын асуудал эрхэлсэн төрийн болон мэргэжлийн байгууллагуудын үүрэг, оролцоо, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа дутмаг байна.

25 НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрмүүд (Бээжингийн дүрмүүд)

- **Урьдчилан хорих анги буюу Цагдан хорих байранд хоригдож буй хүүхдүүдийн сурч боловсрох эрх**

Манай улсад урьдчилан хорих анги буюу Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч хүүхдүүд хүнд нөхцөлд байгаа бөгөөд тэдний сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах эрх ноцтой зөрчигдөж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа цагдан хорих байрнуудад цагдан хоригдсон 14-18 насны хүүхдийн судалгааг 2024-2025 оны байдлаар гаргаж хүргүүлснээс харахад 53 хүүхэд (үүнээс 50 эрэгтэй, 3 эмэгтэй) 1 хоногоос 9 сар хүртэл хугацаагаар хоригдрж байна. 2 хүүхдээс бусад нь ЕБС, политехник коллеж, МСҮТ-д суралцаж байсан байна²⁶.

УБ хот дахь Цагдан хорих 461-р хаалттай ангид хоригдож буй хоригдогч хүүхдүүдэд газар зүйн хичээлээс зарим сэдвийг болон хувь хүний хөгжлийн талаарх сургалтыг хорих ангийн нийтийн үзель ашиглан 14 хоногт 1 удаа сонсгох хэлбэрээр явуулдаг бол монгол хэл, математикийн хичээлийг зөвхөн бие даалтын материалыг тарааж өгөх хэлбэрээр явуулдаг. Хүүхдүүд 3-хан төрлийн хичээлээ нэг л дэвтэр дээр хийж, хорих ангийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтанд шалгуулдаг байна.

Цагдан хорих байр нь хаалттай хорих ангийн дэглэмтэй байдаг учир харьяалах Насан туршийн боловсролын төвийн болон ерөнхий боловсролын сургуулийн багш нар дотогш нэвтэрч, сургалтын үйл ажиллагаа явуулах боломж огт байхгүй.

Бусад 21 аймаг дахь Цагдан хорих байруудад хоригдож буй хүүхдүүд хичээл болон бусад төрлийн хүмүүжил төлөвшил, хөгжлийн үйл ажиллагаа хамрагддаггүй байдалтай байна.

Боловсролын яамнаас гаргаж буй бүхий л хууль, журамд “эрх нь хязгаарлагдсан хүүхэд, залуус, насанд хүрсэн иргэд” гэсэн нэршлийг багтааж, шинэчлэн найруулагдаж буй ШШГТХуулинд өсвөр насны хүмүүжигчийн болон насанд хүрсэн иргэдийн сурч боловсрох эрхэд халдсан бүхий л зүйл, заалтыг өөрчлөх; бүх шатны боловсролын сургалтуудыг бусад сургалтуудаас ялгаж, зүйл заалтуудыг илүү тодорхой, нарийвчилж оруулж өгөх; “Хорих ангийн дотоод журам”-ыг шинэчлэх; сурч боловсрох эрхийг хязгаарласан зүйл, заалтуудыг өөрчлөх шаардлагатай гэж иргэний нийгмийн байгууллагууд үзэж байна.

